Хоол зүйч Монгол түшмэл нарын хятад хэлээр туурвисан бүтээл дэх арьсны өвчин судлалтай холбоотой баримтуудыг тодруулан судалсан нь

Хөгжилт (Hugejiletu)[1], С.Доржбат[1], Я.Энхтөр[2], Ш.Болд[3,4]

[1]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, АУС
[3]"Ач" АУИС
[4]Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль
Цахим шуудан: boldshrv@gmail.com, Утас: 80687670

Түлхүүр үг:
Хоол зүйч
Хүсэхүй
Арьсны өвчний түүх
Арьсны өвчин

Товч утга:
Үндэслэл: Монголчуудын бүтээн бий болгосон арьсны өвчин судлалтай холбоотой өв, уламжлалыг судлахдаа юуны өмнө түүх, эх сурвалжийн судалгаагаар дамжуулан арьс судлалын онолын ойлголт, арьсны өвчнийг эмчлэх, түүнээс сэргийлэх аргыг орчин цагийн анагаах ухааны арьс судлалын салбарын хөгжилтэй хослуулан шинэчлэх нь нэн чухал шаардлагатай байна. Тиймээс 1330 онд Хятад хэлээр бичсэн Хүсэхүйн "Идээ, ундааны жинхэнэ товч" номонд буй арьс судлалтай холбоотой мэдээ, баримтуудыг судлах нь бидний судалгааны үндэслэл боллоо. **Зорилго:** Хүсэхүйн "Идээ, ундааны жинхэнэ товч" номонд буй арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээ, баримтууд, арьсны өвчний нэршил, ангиллыг тодруулан судлах. **Арга, аргачлал:** Уламжлалт анагаах ухааны судрууд нь уг гарал, бүтцийн хувьд олон шинжлэх ухааныг хамардаг учраас шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг системийн нийтлэг аргуудыг ашиглах нь нэн зохимжтой байдаг. Бид уг номонд буй шинжлэх ухааны ойлголтуудыг стандартчилах, цэгцлэх, ялангуяа анагаахын шинжлэх ухааны онол, өвчний ангилал, нэр томьёо, төсөөллийг системчлэх, нэг мөр болгох, арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээ, баримтуудыг тогтооход системийн түгээмэл, нийтлэг аргыг нэгтгэн дүгнэх, судлан гаргахад ашиглав. **Үр дүн:** Монгол эрдэмтдийн Хятад хэлээр бичсэн ном судрын дотроос одоогоор хамгийн их судлагдсан ном нь 14 дүгээр зууны Монголын анагаах ухааны эртний бүрэн зохиол болох **Хүсэхүйн 1330 онд бичсэн** "Идээ ундааны жинхэнэ товч" зохиол юм. Өнөөгийн байдлаар Монгол Улсын арьс судлалын түүх сүүлийн 100 жилээр хязгаарлагдаж байгаа ба "Идээ ундааны жинхэнэ товч" бүтээлд байгаа арьс судлал, арьсны өвчтэй холбоотой баримтуудыг нэг бүрчлэн судалснаар уг салбарын түүхийг 14 дүгээр зуунаас эхлүүлэх баримт буй нь тодорхойлогдлоо. **Дүгнэлт:** Юань улсын Монгол хаадын идээ ундааг хариуцсан эмч түшмэл, Монгол үндэстэн Хүсэхүйн 1330 онд хятад хэлээр бичсэн "Идээ, ундааны жинхэнэ товч" зохиолд буй арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээлэл, арьсны өвчний нэршил, ангилал нь Монголын анагаах ухааны хамгийн эрт үеийн сурвалж бичгийн баримтууд юм. **Бидний олж тогтоосон анагаах ухааны олон салбарын эмчилгээ, засалд идээ ундаагаар эмчлэх аргын хүрээнд арьсны өвчтэй холбоотой нийт 12 баримт байв**. Эдгээр баримтуудад арьс хөрс хатангиртах, арьс хөрсөнд халуун яр шарх гарах, арьс мах татвалзах гэсэн арьсны өвчтэй холбоотой 3 нэршил байгааг тодруулав. Бусад нь баримт нь эрүүл арьсны шим тамир, арьс махыг шимжүүлэх, арьс хөрсийг цэвэршүүлэх, арьс махыг төлжүүлэх, арьс хөрсийг өнгөжүүлэх, арьсны өнгийг сэргээх тус эрдэмтэй идээ ундаа, эмийн талаар өгүүлсэн байнгаа нь тогтоогдлоо.

Үндэслэл: Монголчуудын бүтээн бий болгосон арьсны өвчин судлалтай холбоотой өв, уламжлалыг судлахдаа юуны өмнө түүх, эх сурвалжийн судалгаагаар дамжуулан арьс судлалын онолын ойлголт, арьсны өвчнийг эмчлэх, түүнээс сэргийлэх аргыг орчин цагийн анагаах ухааны арьс судлалын салбарын хөгжилтэй хослуулан шинэчлэх нь нэн чухал шаардлагатай байна. Ингэхдээ одоо мэдэгдэж байгаа Монголын анагаах ухааны эртний зохиол Хүсэхүйн 1330 онд хятад хэлээр бичсэн "Идээ, ундааны жинхэнэ товч", арван наймдугаар зууны сүүл хагаст манж хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлсэн "Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг"-ийн арьсны өвчин судлалтай холбоотой түүхэн уламжлалыг судлах, уг бүтээлүүдэд байгаа орчин цагийн анагаах ухаан дахь арьсны өвчнийг эмчлэх талаар баримталж байгаа онол, зарчим, аргатай холбоотой түүхэн мэдээллүүдийг нэгтгэх, Монгол улс төдийгүй анагаах ухааны өнө эртний түүхтэй хөрш орон болох БНХАУ-ын уламжлалт анагаах ухааны салбарын арьсны өвчин судлалын баримтуудтай харьцуулан судлах нь нэн чухал ач холбогдолтой юм.

"Идээ, ундааны жинхэнэ товч" зохиолыг БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-д орчуулагч Хөхлуу Хятад хэлнээс Монгол хэлээр хэсэгчлэн орчуулж байгаад 1980 онд бүрэн орчуулж, 1982 онд хэвлүүлсэн байна[1]. Ингэж энэ номыг судлах, кирилл үсгээр буулгах боломж Хөхлуу нараас улбаалан бүрдэж Монгол улсад анхны хөрвүүлгийг Г.Пагма нар хийж Эрдэнэт хотод 1990-ээд оны сүүлээр хэвлүүлсэн баримт байна[2].

2002 онд судлаач Ш.Болд, М.Амбага нарын "History and Fundamentals of Mongolian Traditional Medicine" номонд анх удаа англи хэлээр уг бүтээлийн агуулгын талаар дурдсан ба Ш.Болд нарын 2007 онд "Insight into the Secrets of a Mongolian Healthy Life-style" [3,4] бүтээлд "Идээ ундааны жинхэнэ товч" номын эрүүл аж төрөхөд цээрлэх зүйл, жирэмсэн эмэгтэйн идээ, ундааны цээрлэх зүйл, төрсөн эхийн цээрлэх зүйл, архи дарс уух үед цээрлэх зүйлийг англи хэлээр орчуулан хэвлүүлжээ.

Түүнчлэн ШУТИС-ийн судлаач Д.Оюун-Эрдэнэ нар 2008 онд энэхүү бүтээлийг хоол зүй, шим тэжээл талаас нь судлан магистрын зэрэг хамгаалсан байна[5]. Мөн судлаач Т.Алимаа, С.Сэдэддулам нар "Идээ ундааны жинхэнэ товч" номыг монгол бичгээс хөрвүүлэн 2012 онд хэвлүүлсэн байна[6]. БНХАУ-ын ӨМӨЗО-ны судлаач Урнаа "Идээ ундааны жинхэнэ товч" номыг судлаач С.Сээсрэгдорж нарын удирдлагаар судлан 2017 онд магистрын, 2000 онд АУ-ны докторын зэргийг тус тус хамгаалжээ [7]. "Идээ ундааны жинхэнэ товч" номын Мин улсын үеийн хэвлэлийг Судлаач Ш.Болд нар "A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao" англи хэлээр бичсэн бүтээлтэй харьцуулан Монгол хэлээр орчуулж, зарим бэрх үг, нэрийн болон зохиолчийн гарал үүслийн тайлбарыг дагалдуулан судалсан байна [8]. Хэдийгээр "Идээ ундааны жинхэнэ товч" номыг цөөнгүй судлаачид идээ, ундаа, шим тэжээл, түүхэн гарвал, зохиогчийн гарал үүсэл, орчуулгын талаар өргөн хүрээнд судалсан ч арьс судлал талаас нь судалсан эрдэм судлалын ажил олдохгүй байна. Тиймээс 1330 онд Хятад хэлээр бичсэн Хүсэхүйн "Идээ, ундааны жинхэнэ товч" номонд буй арьс судлалтай холбоотой мэдээ, баримтуудыг судлах нь бидний судалгааны үндэслэл боллоо.

Зорилго: Хүсэхүйн "Идээ, ундааны жинхэнэ товч" буй арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээ, баримтууд, арьсны өвчний нэршил, ангиллыг тодруулан судлах.

Арга, аргачлал:

Судалгааны хэрэглэгдэхүүн: Хүсэхүй. "Идээ, ундааны жинхэнэ товч" 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022, A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010


Судалгааны арга:

1. Системийн түгээмэл, нийтлэг арга: Уламжлалт анагаах ухааны судрууд нь уг гарал, бүтцийн хувьд олон шинжлэх ухааныг хамардаг учраас шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг системийн нийтлэг аргуудыг ашиглах нь нэн зохимжтой байдаг байна[9]. Бид уг номонд буй шинжлэх ухааны ойлголтуудыг стандартчилах, цэгцлэх, ялангуяа анагаахын шинжлэх ухааны онол, өвчний ангилал, нэр томьёо, төсөөллийг системчлэх, нэг мөр болгох, арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээ, баримтуудыг тогтооход системийн түгээмэл, нийтлэг аргыг нэгтгэн дүгнэх, судлан гаргахад ашиглав.
2. Контент анализийн арга: Бид мөн баримтаас түүний агуулгад шууд хамаарах дүгнэлт гаргахад чиглэсэн судалгааны арга Контент анализийн аргын эх бичвэрийг олон талт, олон хэмжигдэхүүн бүхий аргаар тоон, чанарын, шугаман загваруудыг тус тус ашиглан Хүсэхүйн "Идээ, ундааны жинхэнэ товч" номоос арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой баримт, арьсны өвчний зүйл, ангиллыг судлан тодруулав[10].

Үр дүн: Уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн судлалд хятад хэлээр бичсэн эртний бүтээлийг орчуулах, эх бичгийн судалгаа хийх, сургалт, практикт ашиглах нь Монголын уламжлалт анагаах ухааны тулгамдсан асуудал болж байна. Ялангуяа уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжсөн сүүлийн 30 гаруй жилд хятад хэлээр Монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний номуудыг олж тогтоох, жагсаалт гаргах, орчуулах ажил харьцангуй бага хийгджээ.

Хятад хэлээр Монгол эрдэмтдийн бичсэн ном судрын дотроос одоогоор хамгийн их судлагдсан ном нь 14 дүгээр зууны Монголын анагаах ухааны эртний бүрэн зохиол бол Хүсэхүйн 1330 онд бичсэн "Идээ ундааны жинхэнэ товч" зохиол юм. Энэ бүтээлийг судалж хоол, ундны хэрэглээг шинжлэх ухааны үндэстэй болгох, шим тэжээлийн чиглэлийн судалгааг өргөжүүлэх эрдэм шинжилгээний ажлыг хоол, хүнс, анагаах ухааны салбарт хийх нь нэн чухал юм. Ялангуяа өвчний шалтгаан, нөхцөл, эмгэг жам, эмчлэх зарчим, аргандаа тохирсон хоол, ундыг хэрэглэх, ингэснээрээ өвчнийг эмчлэх хугацааг богиносгох,

эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, урхаггүй эдгээх зорилгод хүрэх зайлшгүй шаардлага тавигдсаар байна. Энэхүү шаардлагыг биелүүлэхэд эмчилгээний хоолны талаар хуримтлуулсан эрт цагийн туршлага, мэдлэгийг нэгтгэн, зарим хоолыг өөрийн орны нөхцөлд, хүн зоны бие махбодын онцлогт тохируулан шинжлэх ухааны үндэслэлтэй болгох нь чухал юм. (Зураг 1)



Зураг 1. “Идээ ундааны жинхэнэ товч” номын Мин улсын Жинтайн хэвлэл

“Идээ ундааны жинхэнэ товч” бүтээлд өвчний шалтгаан нөхцөл, эмгэг жамын талаар нарийн тодорхой тэмдэглээгүй ч идээ, ундаагаар эмчлэх аргын талаар энгийн бөгөөд ойлгомжтой бичиж, олон жишээ баримтуудыг оруулж өгчээ[11]. Түүнчлэн уг бүтээлийг зөвхөн идээ ундааны хэрэглээ талаас нь бус Монголын анагаах ухааны салбар бүрт ямар нөлөө үзүүлсэн, тухайн салбартай холбоотой ямар баримт, мэдээлэл байгааг нээн гаргах боломжтой гэдэг нь бидний судалгааны явцад батлагдаж байна. Үүний жишээ нь “Идээ ундааны жинхэнэ товч” ном, түүний агуулгыг нарийвчлан судлахад Монголын анагаах ухааны арьс судлал, арьсны өвчин судлалын хөгжлийг хэдэн зуунаар урагшлуулан авч үзэх боломжтой байгаад оршино. Өнөөгийн байдлаар Монгол Улсын арьс судлалын түүх сүүлийн 100 жилээр хязгаарлагдаж байна. Гэтэл “Идээ ундааны жинхэнэ товч” бүтээлд байгаа арьс судлал, арьсны өвчтэй холбоотой баримтуудыг нэг бүрчлэн түүж гарган судалснаар уг салбарын түүхийг 14 дүгээр зуунаас эхлүүлэх баримт буйг дараах байдлаар магадлан жагсаав. Үүнд:

1. Исгэлэн, эхүүн, гашуун, давслаг, амтлаг, гошуун амттай идээ, ундаанаас гошуун (хурц) амт бол өөдлөн бадрах эрдэм бүхий тул хэтэрхий идвээс дээш уушгинд гүйснээс болж арьс махны шим тамир хөнөөгдөж зүрхний тамирыг хооссруулна.
2. Гашууныг илүү идвээс дэлүүний шим шүүс дутагдан ходоодны тамир арвидсанаас арьс хөрс хатангиртан үс зулгарна.
3. Хөнөөлт үндсийн идээ (恶实粥) нь саа өвчин тусаад халуурч ам хатах, хөл гар мэдээгүй болох бөгөөд арьс хөрсөнд халуун яр шарх гарахыг эмнэнэ.
4. Дилгар амтлаг амттай, их хүйтэн чанартай, хоргүй. Тамир дорой архагийг тэтгэж, ходоод, гэдсийг тослог болгож, хийг явуулж, цусны судлыг нэвтрүүлэн, толгойн хийг арилган, арьс махыг шимжүүлнэ.
5. Архи бол гашуун, гошгуун амттай, их халуун бөгөөд хортой. Энэ нь эмийн эрдэм чадал эмийн хөлөг болох, идээний хорыг нядалж, цусны судлыг нэвтрүүлэн, ходоод, гэдсийг төлжүүлж, арьс хөрсийг цэвэршүүлж, зовиур гунихралаа арилгана.
6. Панмайбрайбүгийн архи бол Ганжуу (广州) газрын панмайбрайбугээр ёсчлон нэрсэн архи бөлгөө. Энэ нь тамир доройг сэлбэн, арьс махыг төлжүүлэн, дуслын тамирыг тэтгэж хүйтэн хийг арилган, эрэгтэйчүүдийн бэлгийн тамирыг нэмэгдүүлнэ.
7. Тэмээний мах аливаа салхины гэмийг засаж хийг доош татаж, яс шөрмөсийг чангаруулан арьс хөрсийг шимжүүлж, аливаа эдгэршгүй шархираа ба хий хуян, арьс махны татвалзал хийгээд хортой яр шарх, хөхөвтөр хавдрыг эмнэнэ.
8. Шоо бугын мах амтлаг амттай, бүлээн чанартай, хоргүй. Өөх бол гошгуун амттай, бүлээн чанартай, хоргүй. Голдуу боом хавдар, муу чанартай яр шарх, хий хуянгаар дөрвөн мөч татаж атирахыг засаж, цусны судлыг нэвтрүүлэн арьс хөрсийг өнгөжүүлэн шимжүүлнэ. Арьсаар нь гутал хийж өмсвөөс хөлийн бэлцрүү өвчнийг арилгана.
9. Хээрийн (зэрлэг) гахайн мах гашуун амттай, хоргүй. Энэ нь арьс махыг төлжүүлэн, хүний биеийн хийг дарж мариалуулна. Эм гахайн мах нь үнэр амтаар нэн сайн болой.
10. Цагаан галууны мах хоргүй, таван цулын халууныг арилган, ундаасахыг зогсоож, өөх нь арьс хөрсийг шимжүүлэх бөгөөд голдуу чих дүлийрснийг засна.

Гэрийн галууны өндөг бол таван цулыг сэлбэн тамирыг сайжруулна.

11. Цул сараана гошуун амттай, тэгш чанартай, хортой. Энэ нь ходоод, гэдсийг тэтгэн, арьс, махыг төлжүүлж, ходоодонд цугларсныг туулгана. Зэрлэг цул сарааныг идэж үл болно.
12. Нойтон цагаан гаа гошуун амттай, өчүүхэн бүлээн чанартай, хурмал хижгээр толгой өвдөх, ханиаж хий агсахыг дарж, арьсны өнгийг сэргээнэ гэжээ.

Дээрх 12 баримтад дурдсан арьс судлал, арьсны өвчтэй холбоотой мэдээллийг тусгайлан түүвэрлэн, нэгтгэвэл:

1. арьс махны шим тамир
2. арьс хөрс хатангиртах
3. арьс хөрсөнд халуун яр шарх гарах
4. арьс махыг шимжүүлэх
5. арьс хөрсийг цэвэршүүлэх
6. арьс махыг төлжүүлэх
7. арьс хөрсийг шимжүүлж, арьс мах татвалзах
8. арьс хөрсийг өнгөжүүлэх
9. арьс махыг төлжүүлэх
10. арьс хөрсийг шимжүүлэх
11. арьс, махыг төлжүүлэх
12. арьсны өнгийг сэргээх гэсэн байна.

Эдгээрээс арьс хөрс хатангиртах, арьс хөрсөнд халуун яр шарх гарах, арьс мах татвалзах гэсэн арьсны өвчтэй холбоотой 3 нэршил (хэлж тогтсон нэр) байна. Бусад нь эрүүл арьсны шим тамир, арьс махыг шимжүүлэх, арьс хөрсийг цэвэршүүлэх, арьс махыг төлжүүлэх, арьс хөрсийг өнгөжүүлэх, арьсны өнгийг сэргээх тус эрдэмтэй идээ ундаа, эмийн талаар өгүүлжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. “Идээ ундааны жинхэнэ товч” номонд буй арьстай холбоотой зарим түүвэр нэрийн тайлбар

Түүвэр нэр	Тайлбар
арьсны шим тамир	Арьсны чийгийг хадгалах, зөөлрүүлэх, шим тэжээллэг байдал. Арьсны шим тамирыг хадгалахад эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээлээр баялаг, өдөр тутамдаа арьсанд нэн шаардлагатай эрдэс бодис, олон төрлийн аминдэмүүд агуулсан гошуун амттай идээ, ундаа өгөх.
арьс махыг шимжүүлэх	Арьсны ядаргаа, сульдал, шим хомсдох үед шимжүүлэх, сэргээх үйлдэлтэй арга болно. Ялангуяа арьсны мэдрэл булчингийн үйл ажиллагааг сэргээх, шимтэй болгох.
арьс хөрсийг цэвэршүүлэх	Арьс нөхөн сэргэх үед илүүдэл тослог ялгардаг. Тиймээс арьсны гадаргуу дээрх илүүдэл тос, үхэжсэн хэсэг, бохирдлыг цэвэрлэх. Арьсыг цэвэрлэх нь үрэвсэхээс сэргийлэх, үрчлээ, хөгшрөлтийн нөсөө толбо, мөн уян хатан чанараа алдах эрсдэлийг бууруулна.
арьс махыг төлжүүлэх	Арьсны эд, эсүүдийг нөхөн төлжүүлэх байдал. Өөрөөр хэлбэл арьсыг эрчимтэй төлжүүлэх, хамгаалах, давхар зөөлрүүлэх үйлчилгээ.
арьсны өнгийг сэргээх	Арьсны чийгийг хангах, бодисын солилцоог сайжруулах, давхар цэвэршүүлэх үйлчилгээ.

Зарим үгийн тайлбар:

1. Хөнөөлт үндсийн идээ хятадаар 恶实粥 È shí zhōu, англиар Evil root porridge гэдэг. Энэ эмийн түүхий эдийг одоо ч Хятад анагаах ухааны практикт саа өвчинд хэрэглэдэг эмийн найрлагад оруулдаг.
2. Дилгар, цагаан балин буюу цагаан мааж амтлаг амттай, их хүйтэн чанартай, хоргүй.
3. Панмайбрайбүгийн архи-Ганжуу (广州) Гуандун хотын нийслэл ба дэд мужийн хотын панмайбрайбугээр ёсчлон нэрсэн архи.
4. Шоо бугын-бие нь бага, улаавтархан өнгөтэй, толботой цоохор зүстэй нэгэн зүйл буга. Мах нь амтлаг амттай, бүлээн чанартай, хоргүй.
5. Цул сараана-тахианы өндөгний хэртэй том хэмжээтэй, нэгэн зүйл сараана, хальсны өнгө хөхөвтөрхөн, боловсруулж иднэ. Гошуун амттай, тэгш чанартай, бас хортой хэмээдэг. Цул гэдэг нь нэг өнгийн гэсэн утгатай.

Хэлцэмж: Юань улсын үеийн Монгол хаадын идээ, ундаа, шим тэжээлийн түшмэл Хүсэхүй “Идээ ундааны жинхэнэ товч” зохиолоо 1314-1320 оны хооронд хятад хэлээр найруулан бичиж, 1330 онд дуусгажээ[12]. Уг номыг Хубилай цэцэн хааны үеэс эхлэн Заяат хааны үе хүртэлх Монгол хаадын өдөр тутмын зоогийг данслан тэмдэглэж урт хугацаагаар ажиглан шинжилж бичсэн бүтээл гэж үзэж болно. Хожим нь Мин улсын үеийн эм, эмийн ургамлын судлаач Ли Шэ Жин “Өвсөн эмийн товч” (Ben cao gang mu) зохиолдоо дээрх зохиолыг “Хубилайн идээ, ундааны жинхэнэ товч” хэмээн өгүүлсэн байдаг. Энэхүү ном нь нэг талаасаа Монголын анагаах ухааны одоогоор олдоод байгаа эртний, хамгийн иж бүрэн бүтээл нөгөө талаас анагаах ухааны олон салбарын эмчилгээ, заслыг идээ ундаагаар эмчлэн засах аргын хүрээнд нэгтгэн бичсэн гол сурвалж юм. Тухайн үедээ “Идээ ундааны жинхэнэ товч” Юань гүрний харьяа нийт улс, үндэстний эрүүл мэнд, сайн сайхан амьдралын төлөө бичсэн болох нь тодорхой байна. Тухайлбал, “Эдүгээ Богд эзэн нь дээд тэнгэрийн ёсыг уламжилж, Буянт хатан нь дундад хөршийн ёсыг эрэгээр хүлээсэн болой. Тэнгэр газрын ёс хөгжингүй бүрдсэн нь яг энэ цаг үе мөн буй заа. Ард иргэд, аливаа бодис энэхүү цаг үед өсөж төрсөн нь юутай завшаан аж. Тус бичгийг ухуулан дэлгэрүүлэхээс дэлхий дахины хойч үеийн хүмүүс өнөө төрийн дээд мэргэн зузаан хишгийг дурсан мэдэхийг бас юун өгүүлэх” хэмээжээ[13].

Бидний олж тогтоосон анагаах ухааны олон салбарын эмчилгээ, заслыг идээ ундаагаар эмчлэн засах аргын хүрээнд нэгтгэн бичсэн гол сурвалж болохын

хувьд арьс судлал, арьсны өвчний эмчилгээний талаар ч олон арван баримт агуулжээ. Уг бүтээлээр дамжуулан Монголын Юань улсын үеийн анагаах ухааны тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсэг Хятадын анагаах ухааны арьс судлалын хөгжил тухайн үедээ Монгол анагаах ухааны арьс судлалын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Хятад анагаах ухааны арьсны өвчний талаарх хамгийн эртний баримтууд нь Шан гүрний үеийн (НТӨ 1100-1700) түүхийн эхэн буюу амьтны ясанд арьсны өвчний нэрсийг сийлж байсан үеэс эхэлдэг. Жишээлбэл, энэ疕 ханзыг эрт дээр үед толгой, нүүрний шархыг илэрхийлэхэд ашигладаг байсан бол疥 ханзыг хамуу өвчнийг илэрхийлэхэд ашигладаг байжээ. Энэ хоёр ханз өнөөг хүртэл хэрэглэгдэж байна[14]. Хятадын анагаах ухааны арьс судлалын практик нь наад зах нь НТӨ 200-аад оны үеэс эхэлсэн түүхтэй байдаг. Тухайн үед шархны эмч (yang yi) гар, хөл, мөчний арьсны шархыг нээх, хусах, цэвэрлэх, үхсэн эдийг арилгах эмнэлгийн тусламжийг үзүүлж байсан. Цаг хугацаа өнгөрөхөд эдгээр аргуудыг боловсронгуй болгон өргөжүүлж, арьс судлалын (дерматологи) дараа дараагийн ололт амжилттай нэгтгэн, Хятадын уламжлалт анагаах ухааны арьс судлалын тогтолцоог бүрдүүлжээ.

Нүүдэлчин монголчууд үндсэн амжиргаа болох мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ 13, 14 дүгээр зууны үед цэрэг, дайны **үйл ажиллагаа тасралтгүй явуулж үүнийгээ дагаад цэргийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх аргаа боловсронгуй болгосоор байжээ. Нөгөө талаар дайны явцад эсрэг этгээдийн цэргийн эмнэлгийн тусламж, анагаах ухааны ололтод нөлөөлсөн байна. Юань улсын үеийн эмч** Qi Dezhi-ийн 1335 онд бичсэн “Гадар заслын нэн чухал үндэс” (Waike Jingyi) [15] номонд шарх, буглаа арилгах мэс заслын олон аргыг тоймлон, эм найрлага, талх эм, тос зэргийг ашиглан эмчлэх аргуудыг тэмдэглэсэн байна. Түүнчлэн арьсны өвчин нь билгийн тэнцвэргүй байдлын үр дагавар гэж үзэн, ургамлын эмчилгээ нь арьсны өвчнийг анагаах салшгүй хэсэг гэдгийг онцлон дурджээ. Энэ санааг ч “Идээ, ундааны жинхэнэ товч” номын агуулгад оруулж өгсөн нь илэрхий байна.

Олон зууны туршид өвчний нэршил улам бүр боловсронгуй болж, Манж Чин гүрний дунд үе (1644-1911) гэхэд арьсны өвөрмөц нэршлийг тогтоон практикт хэрэглэж байв. Жишээлбэл, пурпура-улаан эсэргэнэ-Zǐdiàn fēng (紫癜風), арьсны саажилт - Pibi (皮痹), атопик дерматит буюу эпидермисийн хоригийг бүрдүүлэгч уургийн генийн мутацаас үүсэлтэй архаг явцтай арьсны өвчин - Sì wān fēng (四灣風) гэх мэтээр дурдаж болох байна[16]. Гэтэл Манжаас өмнө Юань улсын үед монголчууд арьс хөрс хатангиртах - Skin atrophy, арьс хөрсөнд халуун яр шарх гарах-Skin redness or inflammation, арьс, мах татвалзах - Amyotrophic lateral sclerosis (ALS) гэсэн оношт тавьж уг өвчнийг эмчлэх талаар “Идээ ундааны жинхэнэ товч” номонд тэмдэглэн үлдээжээ. Гэхдээ эмчилгээний аргын хувьд нийлмэл жор, эм найрлагын хувьд бус харин хүний өдөр тутмын шим тэжээлийн эх үүсвэр, өвчлөх, эс өвчлөх, эмчлэн засах үндэс болсон идээ ундаанд хэрэглэдэг амьтан, ургамлын гаралтай идээ ундааг эм болгон хэрэглэх шинэ мэдлэгийг бүтээсэн хосгүй, ховор бүтээл юм.

Дүгнэлт: Юань улсын Монгол хаадын идээ ундааг хариуцсан эмч түшмэл, монгол үндэстэн Хүсэхүйн 1330 онд хятад хэлээр бичсэн “Идээ, ундааны жинхэнэ товч” зохиолд буй арьсны өвчин судлалын хөгжилтэй холбоотой мэдээлэл, арьсны өвчний нэршил, ангилал нь Монголын анагаах ухааны хамгийн эрт үеийн сурвалж бичгийн баримтууд юм. Бидний олж тогтоосон анагаах ухааны олон салбарын эмчилгээ, засалд идээ ундаагаар эмчлэх аргын хүрээнд арьсны өвчтэй холбоотой нийт 12 баримт байна. Эдгээр баримтуудад арьс хөрс хатангиртах, арьс хөрсөнд халуун яр шарх гарах, арьс мах татвалзах гэсэн арьсны өвчтэй холбоотой 3 нэршил байгааг тодруулав. Бусад нь баримт нь эрүүл арьсны шим тамир, арьс махыг шимжүүлэх, арьс хөрсийг цэвэршүүлэх, арьс махыг төлжүүлэх, арьс хөрсийг өнгөжүүлэх, арьсны өнгийг сэргээх тус эрдэмтэй идээ ундаа, эмийн талаар өгүүлсэн байна.

Ном зүй:

1. *Хүсэхүй. “Идээ, ундааны жинхэнэ товч” 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022, х.28*
2. *Хүсэхүй. “Идээ ундааны жинхэнэ товч” (хөрвүүлсэн Г.Пагма, тайлбар хийж редактор Д.Дэмбэрэлдорж), Эрдэнэт хот.*
3. *Bold Sh, Ambaga M. History and Fundamentals of Mongolian Traditional Medicine. UB, “Sod Press”, 2002, (in English), p.23*
4. *Bold Sh. Insight into the Secrets of a Mongolian Healthy Lifestyle. Ulaanbaatar, “Munkhiin useg” Printing House, 2007*
5. *Д.Оюун-Эрдэнэ. Хубилай цэцэн хааны “Идээ ундааны жинхэнэ товч” зохиолыг судлах асуудалд (XIV зуун). Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ШУТИС, УБ, 2008*
6. *Т.Алимаа, С.Сэдэддулам. “Идээ ундааны жинхэнэ товч”. УБ, “Мөнхийн үсэг”, 2012*
7. *Хүсэхүй. “Идээ, ундааны жинхэнэ товч” 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022*
8. *“A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui’s Yinshan Zhengyao” Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010*
9. *Churchman, C.W. 1968. The Systems Approach. New York, NY, USA: Dell Publishing.*
10. *Klaus H. Krippendorff. Content Analysis, An Introduction to Its Methodology. 2018*
11. *Хүсэхүй. “Идээ, ундааны жинхэнэ товч” 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022, х.16*
12. *Хүсэхүй. “Идээ, ундааны жинхэнэ товч” 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022, х.26*
13. *Хүсэхүй. “Идээ, ундааны жинхэнэ товч” 1330. Орчуулж тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022, х.48*
14. *Mazin Al-Khafaji, CM, Lac, FRCHM, MATCM. Chapter 1. Introduction to Chinese Medicine Dermatology part 1 overview of TCM. An Introduction to Chinese Medicine Dermatology by Learn Skin and ITCMDA.pdf, p.1*
15. *Taha A, Kamal HN, Ali MH, Saud MJ, Sabit SH (2022) History of Traditional Chinese Medicine. History of Medicine 8(1): 7–17. https://doi.org/10.17720/2409-5834.v8.1.2022.002*
16. *Mazin Al-Khafaji, CM, Lac, FRCHM, MATCM. Chapter 1. Introduction to Chinese Medicine Dermatology part 1 overview of TCM. An Introduction to Chinese Medicine Dermatology by Learn Skin and ITCMDA.pdf, p.1*